

Энэхүү дүрмийг 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Форумын хурлаар хэлэлцэн батлав. Нийт 24 байгууллага оролцов.

ХҮНИЙ ЭРХИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ФОРУМЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Хүний эрхийн төлөө ажилладаг төрийн бус, ашгийн бус, улс төрийн нам бус байгууллагууд сайн дурын үндсэн дээр 2010 оноос хойш нэгдэж Хүний Эрхийн Төрийн Бус Байгууллагуудын ФОРУМ байгуулсан билээ. Энэхүү дүрмийг ХЭТББФд-д албан ёсоор нэгдсэн байгууллага бүр дагаж мөрдөнө.
- 1.2 “Хүн бүрт эрх тэгш боломж, эрх мэдлийн тэгш, шударга хуваарилалт бий болгох нийгмийн шударга ёсыг эрхэмлэх явдал” нь бидний үнэт зүйл мөн.
- 1.3 Монгол улсад хүний эрхийг хамгаалах, нийгэм, эдийн засгийн хүрээнд учирч байгаа хүний эрхийн эрсдлийг бууруулах, арилгахын төлөө ажиллах нь бидний эрхэм зорилго мөн.
- 1.4 Монгол улсад хүний эрхийн төлөв байдлын талаар байнгын анхаарал тавьж, НҮБ-ын Хүний эрхийн хороо, олон улсын болон Монгол улсын холбогдох эрх бүхий байгууллагад тайлан явуулах, илтгэл тавих, Зөвлөмжийн дагуу үйл ажиллагаа явуулах, хяналт үнэлгээ хийх үндсэн зорилготой болно.

Хоёр. Бидний үйл ажиллагааны зарчим

- 2.1 *Нээлттэй, ил тод байна.* Форум нь бодлого боловсруулах, үйл ажиллагаа төлөвлөх, хяналт үнэлгээ хийх, гүйцэтгэх, тайлагнах бүхий л үе шатанд бүх гишүүддээ нээлттэй, ил тод байна.
- 2.2 *Оролцоог хангаж, олонхоор асуудлыг шийдвэрлэнэ.* Аливаа асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэхдээ талуудын оролцоог хангаж, шийдлийг олонхийн саналаар гаргана.
- 2.3 *Сайн дурын гишүүнчлэлд суурилна.* Форумын дотоод журам, зарчмыг хүлээн зөвшөөрч, зорилгыг дэмжсэн, гишүүний шаардлагыг хангасан аливаа байгууллагыг эгнээндээ нэтгэх, улмаар олон байгууллагыг оролцуулах стратеги баримтлана.

2.4 Мэргэжлийн түвшинд ажиллана. Хүний эрхийг дэмжих, хамгаалахад чиглэсэн аливаа үйл ажиллагаанд хуулийн дагуу, хүний эрхэд суурилсан мэдлэг, хандлага, чадвараар гүйцэтгэнэ.

2.5 Форум нь бие даасан нэгдэл бөгөөд Ээлжит хурлаар эрх олгосноос бусад тохиолдолд хэн нэг гишүүн дангаар төлөөлөхгүй болно.


Эдгээр зарчмын хэрэгжилтийг Ёс зүйн хороо хянаж ажиллана.

Гурав. Үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт

3.1 Форумын үндсэн үйл ажиллагаа нь бүх гишүүдийн хурал байна. Хурал нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байх бөгөөд тусгай дэгээр зохицуулагдана.

3.2 Хурлыг тухайн сарын Даргалагч байгууллага зохион байгуулах бөгөөд Ээлжит хурлаас ээлжит хурлын хооронд үйл ажиллагааг ерөнхийлөн зохицуулж дараагийн ээлжийн байгууллагад хүлээлгэн өгнө.

3.3 Даргалагч байгууллага нь шаардлагатай тохиолдолд “А” бүсийн 5 байгууллагын зохиулагчтай шууд харьцана. “А” бүсийн зохицуулагч нар “Б” бүсийн 5 зохицуулагчтай гэх мэтээр тавтын системээр зохион байгуулалтыг явуулна.



- 3.4 Тавтын зохицуулагчийг улиралд нэг удаа шинэчлэн Ээлжит хурлаар томилно.
- 3.5 Форум нь таван гишүүн байгууллагаас бүрдсэн Хяналтын зөвлөлтэй байна. Хяналтын зөвлөл нь жилд 2 удаа хуралдах бөгөөд Форумын үйл ажиллагаа дүрмийн дагуу явагдаж байгаа эсэхт дүгнэлт гаргаж Бүх гишүүдийн хурлаар танилцуулна.
- 3.6 Шаардлагатай тохиолдолд зохион байгуулах кампанит ажлыг удирдан зохион байгуулах Ажлын хэсэг байгуулж болно.
- 3.7 Хурлын шийдвэрийг хуралд оролцсон гишүүн байгууллагуудын зөвшилцлөөр шийдвэрлэх ба Албан бичгээр үйлдсэн шийдвэр, уриалга, шаардлага, өргөдөл, албан захидал зэргийг албан бланк дээр дэмжсэн байгууллагууд нэг бүр гарын үсэг, тамга зурснаар хүчин төгөлдөр болно.
- 3.8 Жил бүрийн эхний улиралд Форумын үйл ажиллагааны тайланг гаргаж, бүх гишүүдэд болон олон нийтэд мэдээллэнэ.
- 3.9 Жил бүрийн эхний улиралд Форумын бүх гишүүдийн оролцооны статистик гаргаж мэдээллэнэ.

Дөрөв. Хяналтын зөвлөл

- 4.1 Хяналтын зөвлөлийг ээлжит хурлаар, сайн дурын үндсэн дээр хүний нэр дэвшүүлж, олонхийн саналаар 5 гишүүнийг 2 жилийн хугацаатай сонгоно.
- 4.2 Хяналтын зөвлөл нь дараахи үүрэг хүлээнэ. Үүнд:
- 4.2.1 Форумаас явуулж байгаа үйл ажиллагааны хэлбэр, агуулга нь дүрмийн зорилгын хүрээнд буй эсэхт дүгнэлт гаргах
 - 4.2.2 Гишүүн байгууллага нь Форумын дүрмийн дагуу ажиллаж байгаа эсэхт дүгнэлт гаргах
 - 4.2.3 Форумын гишүүн байгууллагаас ирүүлсэн гомдол, хүсэлтийг нягтлан үзэж, дүгнэлт гаргах
- 4.3 Хяналтын зөвлөл нь жилд 2 ба түүнээс дээш удаа хуралдаж, 4.2-т заасан дүгнэлтүүдийг бүх гишүүдийн ээлжит хуралд танилцуулна.

Тав. Гишүүн байгууллагын эрх, үүрэг

- 5.1 Форумд нэгдэх хүсэлтэй ТББ нь Гишүүн байгууллагын сургалтад хамрагдаж, Форумын зарчмыг хүлээн зөвшөөрч, дүрэм, журмыг дагаж мөрдөхөө албан бичгээр илэрхийлсэн хүсэлтийг бүх гишүүдийн ээлжит

хурлаар хэлэлцүүлэх бөгөөд олонхийн саналаар Форумын гишүүнд нэгдэнэ.

5.2 Гишүүнээр нэгдэх хүсэлтийг дараахи бичиг баримтын хамт ирүүлж, хуралд танилцуулна. Үүнд:

5.2.1 Улсын бүртгэлийн гэрчилгээ

5.2.2 Байгууллагын танилцуулга, холбогдох хаяг

5.2.3 Удирдах зөвлөл түүнтэй адилтгах субъектийн танилцуулга

5.2.4 Сүүлийн хоёр жилийн үйл ажиллагааны тайлан

5.3 Ээлжит хурлаар нэгдсэн шинэ гишүүн байгууллагын бүртгэлийг батлагдсан Маягтын дагуу явуулж, баримтжуулан архивлана.

5.4 Гишүүн байгууллага нь Форумд нэгдснээр дараахи эрх эдлэнэ. Үүнд:

5.4.1 Хүний эрхийн ямар ч асуудлаар Форумд үйл ажиллагаа санаачлан хэлэлцүүлэх

5.4.2 Форумаас зохион байгуулагдах сургалт, мэдээлэл бусад үйл ажиллагаанд оролцох

5.4.3 Форумаас зохион байгуулагдаж буй Ажлын хэсэгт орох

5.4.4 Форумын даргалагчаар ажиллах

5.4.5 Гишүүнээс татгалзах бол Форумын элжит хурлаас 14-оос доошгүй хоногийн өмнө бичгээр тухайн сарын Даргалагч байгууллагад мэдэгдэл хүргүүлнэ.

5.5 Гишүүн байгууллага нь дараахи үүрэг хүлээнэ. Үүнд:

5.5.1 Гишүүн байгууллага нь ямар ч тохиолдолд Форумыг дангаар төлөөлөхгүй.

5.5.2 Ээлжит хуралд идэвхтэй оролцох бөгөөд биечлэн оролцох боломжгүй хүндэтгэх шалтгаан үүсвэл урьдчилан мэдэгдэх

5.5.3 Үйл ажиллагааны тайлангаа дараа оны 1 дүгээр улиралд багтаан бүх гишүүдэд танилцуулна.

5.5.4 Даргалагч байгууллагын үүрэг хүлээж ажилласан тохиолдолд тухайн хугацааны Форумын тайланг гаргах

Зургаа. Форумын үйл ажиллагааны хяналт, хариуцлага

6.1 Форумын үйл ажиллагааг сар бүрийн Даргалагч байгууллага хариуцан явуулна.

6.2 Шаардлагатай тохиолдолд хурлаар хэлэлцэн байгуулагдсан Ажлын хэсэг тухайн үйл ажиллагааг хариуцан ажиллана.

6.3 Форумын үйл ажиллагаанд бүх гишүүд хяналт тавьж ажиллах бөгөөд ямар нэг зөрчил илэрсэн гэж үзвэл Хяналтын зөвлөлд шаардлага, мэдээлэл хүргүүлнэ.

6.4 Форум нь бүх гишүүн байгууллагад эрх тэгш үйлчлэх тул Форумын нэрийн өмнөөс хэн нэг байгууллага дангаар төлөөлсөн тохиолдолд Ээлжит хурлаар асуудлыг оруулж, тухайн байгууллагыг гишүүнээс тодорхой хугацаагаар чөлөөлнө.

6.5 Форум өөрийн үйл ажиллагааг дараа оны эхний улиралд багтаан дүгнэнэ. Форумын жилийн эцсийн ээлжит хурлаар үйл ажиллагааны тайлан нэгтгэж, дүгнэх Ажлын хэсэг гаргаж, батлагдсан загварын дагуу гаргана.

Долоо. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

7.1 Энэхүү дүрмийг бүх гишүүдийн ээлжит хурлаар хэлэлцэн олонхийн саналаар баталж, гарын үсэг тамга дарснаар хүчин төгөлдөр мөрдөнө.

7.2 Дүрэмд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд саналаа үндэслэлийн хамт урьдчилан бшх гишүүдэд тарааж, Ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

ХЭТББ Форумын дүрмийг 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр батлав.

Баталсан гишүүд:

Байгууллага:	Тамга, тэмдэг	Хуралд оролцсон хүний нэр
“ЛГБТ ТӨВ” ТББ		М.Шижиртуяа
ГҮНЖ ТӨВ ТББ		Б.Төгөлдөр

ҮНДСЭН УРТРАГ ТББ		С.Цэндбаатар
ХӨГЖЛИЙН ХЭЛХЭЭ ТББ		М.Сүрэн
ХИЛ ХЯЗГААРГҮЙ АЛХАМ ТББ		Н.Баярсайхан
СЭТГЭЛЗҮЙН МЭДРЭМЖ ТӨВ ТББ		Ч.Сэмжидмаа
БУЛАГ ШАНД ГОЛ МӨРНИЙ ЭХИЙГ ХАМГААЛАХ САН ТББ		А.Оюунчимэг
ТУВА ЭЭЖ ТББ		А.Ариунаа

<p>БҮСГҮЙЧҮҮД ХХИЗУУН ТББ</p>		<p>С.Хандсүрэн</p>
<p>ТАТВАРТ ИРГЭНИЙ ХЯНАЛТ ТББ</p>		<p>Д.Сарантуяа</p>
<p>ЗАХИРГААНЫ ШИНЭ САНААЧЛАГА ТББ</p>		<p>С.Цэрэнпүрэв</p>
<p>ЭВТСАЙН ХӨРШ САН ТББ</p>		<p>Б.Норовсүрэн</p>
<p>ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТӨВ ТББ</p>		<p>Б.Сарантуяа</p>
<p>ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ЗАША ӨВС ТӨВ ТББ</p>		<p>Р.Нямдорж</p>

МОНГОЛЫН ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ХОЛБОО ТББ		М.Чинзориг
ЧД-ИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХОЛБОО		С.Чинцогт
САЙН САЙХНЫ ЭХЛЭЛ ТББ		Г.Алтантуяа
ЭМЭГТЭЙЧҮҮД АМЬДРАЛ ТӨВ		Ж.Адъяа
ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ТӨВ ТББ		Б.Арвинтариа
ХҮНИЙ ЭРХ ХӨГЖИЛ ТӨВ ТББ		Г.Уранцоож

<p>МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛМӨРИЙГ ДЭМЖИХ ХОЛБОО</p>		<p>Ш.Ариунаа</p>
<p>МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ ТББ</p>		<p>Б.Алтантуяа</p>

Хуралд Дүмийн төсөл танилцуулж, хэлэлцүүлэн,
эцсийн найруулгыг бэлдэж хэвлэсэн:

Ш.Ариунаа Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг
дэмжих холбооны УЗ-ын дарга

Улаанбаатар хот.
2017.10.18